СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

СБА-2022/04/НА-СТА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он


Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор: А.Мөнхцэцэг

Утас: 70512127 Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 7

3. Аудитын тайлан ........ 8

3.1 Ерөнхий зүйл ........ 8

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 9

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 9

3.4 Материаллаг байдал ........ 9

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 10

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 11

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 11

3.8 Аудитын гол асуудал ........ 11

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...... 11

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 11

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 12

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 12

4. Аудитын илрүүлэлт ........ 12

4.1 Зөвлөмж ........ 12

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 13


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.24 № 20

танай ______________-ны №_______________-т

СҮХБААТАР АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ШҮРЭНЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,619,992.00** | **10,281,481.88** |
| **33** | **АВЛАГА** | 60,000.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 60,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 60,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 5,559,992.00 | 10,281,481.88 |
| **354** | **Хангамжийн материал** | 5,559,992.00 | 10,281,481.88 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,435,620.00 | 3,423,539.88 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,317,712.00 | 3,618,942.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 546,660.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 260,000.00 | 3,239,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **207,248,279.40** | **234,122,534.37** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 207,248,279.40 | 234,122,534.37 |
| **392** | **Биет хөрөнгө** | 190,328,279.40 | 217,202,534.37 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 102,177,883.22 | 101,710,193.22 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -9,463,018.68 | -14,520,086.56 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 121,700,000.00 | 121,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -77,613,888.86 | -86,580,555.50 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 38,183,413.42 | 71,442,058.09 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -6,106,574.54 | -15,351,575.72 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 35,149,023.76 | 55,829,023.76 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -13,698,558.92 | -17,026,522.92 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 16,920,000.00 | 16,920,000.00 |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -770,000.00 | -770,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,920,000.00 | 16,920,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **212,868,271.40** | **244,404,016.25** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **60,000.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 60,000.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 60,000.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 60,000.00 | 00.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 60,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **212,808,271.40** | **244,404,016.25** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 212,808,271.40 | 244,404,016.25 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 215,330,272.02 | 215,330,272.02 |
| 51101 | Өмч: - төрийн | 215,330,272.02 | 215,330,272.02 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -10,333,022.07 | 21,655,532.78 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -10,333,022.07 | -9,940,212.07 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 31,595,744.85 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,811,021.45 | 7,418,211.45 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **212,868,271.40** | **244,404,016.25** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **536,381,335.94** | **731,332,188.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **56,440,135.94** | **28,853,488.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 56,440,135.94 | 28,853,488.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 56,440,135.94 | 28,853,488.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 56,440,135.94 | 28,853,488.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **479,941,200.00** | **702,478,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 479,941,200.00 | 702,478,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 479,941,200.00 | 702,478,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **492,177,868.24** | **699,736,443.15** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **492,177,868.24** | **699,736,443.15** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 489,982,019.65 | 633,747,039.14 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 363,385,431.63 | 426,673,237.21 |
| 210101 | Үндсэн цалин | 259,446,543.86 | 264,010,978.97 |
| 210102 | Нэмэгдэл | 94,207,387.77 | 141,582,258.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,731,500.00 | 21,080,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45,407,533.68 | 54,057,538.75 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,875,539.85 | 37,476,221.68 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,633,001.72 | 4,176,829.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,965,563.37 | 3,307,863.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 667,437.33 | 826,965.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,265,991.41 | 8,269,658.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,056,718.69 | 17,441,096.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,306,712.69 | 1,527,059.55 |
| 210302 | Түлш, халаалт | 12,842,984.00 | 12,909,397.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,683,022.00 | 1,804,640.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,224,000.00 | 1,200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,509,943.41 | 26,373,427.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,988,949.70 | 9,957,079.46 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,649,650.00 | 9,120,460.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,788,139.71 | 2,166,017.74 |
| 210404 | Ном, хэвлэл | 157,100.00 | 409,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 958,580.00 | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 932,524.00 | 3,540,670.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,035,000.00 | 180,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 65,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 65,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,313,500.00 | 47,281,998.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 100,000.00 | 35,998.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,213,500.00 | 47,246,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,570,000.00 | 2,200,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,570,000.00 | 2,200,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,389,253.00 | 19,885,918.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,607,800.00 | 18,589,276.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 961,175.00 | 961,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 171,500.00 | 155,689.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 24,178.00 | 29,178.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 66,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 84,600.00 | 84,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 28,284,639.24 | 39,833,823.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,600,000.00 | 4,553,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,200,000.00 | 7,300,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 21,484,639.24 | 27,980,223.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,195,848.59 | 65,989,404.01 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,965,000.00 | 63,140,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 62,640,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,965,000.00 | 500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 2,849,404.01 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт,** | 230,848.59 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | **шилжүүлэг** | | |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 230,848.59 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **44,203,467.70** | **31,595,744.85** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 232,000.00 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 232,000.00 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -232,000.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **43,971,467.70** | **31,595,744.85** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **215,330,272.02** | **7,811,021.45** | **-10,333,022.07** | **00.00** | 212,808,271.40 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 392,810.00 | 00.00 | 392,810.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **215,330,272.02** | **7,811,021.45** | **-9,940,212.07** | **00.00** | 213,201,081.40 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -392,810.00 | 00.00 | 00.00 | -392,810.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 31,595,744.85 | 00.00 | 31,595,744.85 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **215,330,272.02** | **7,418,211.45** | **21,655,532.78** | **00.00** | 244,404,016.25 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **479,941,200.00** | **702,513,700.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **479,941,200.00** | **702,513,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 479,941,200.00 | 702,478,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 479,941,200.00 | 702,478,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 35,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 35,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **471,503,221.00** | **673,299,710.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **471,503,221.00** | **673,299,710.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **469,307,372.41** | **607,275,305.99** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 363,231,100.00 | 426,733,848.07 |
| 210101 | Үндсэн цалин | 271,839,145.75 | 270,440,017.32 |
| 210102 | Нэмэгдэл | 82,245,154.25 | 135,544,992.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,146,800.00 | 20,748,838.57 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45,407,600.00 | 53,996,927.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,808,100.00 | 37,234,199.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,149,900.00 | 4,222,132.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,519,900.00 | 3,344,145.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 630,000.00 | 835,986.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,299,700.00 | 8,360,464.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,210,984.00 | 17,441,096.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,344,000.00 | 1,540,799.55 |
| 210302 | Түлш, халаалт | 12,842,984.00 | 12,895,497.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,804,800.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,224,000.00 | 1,200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,688,235.41 | 25,883,817.08 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,599,999.70 | 10,574,999.34 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,749,610.00 | 8,099,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,838,999.71 | 2,199,817.74 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 409,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,149,000.00 | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,150,626.00 | 3,600,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 65,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 65,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,500,000.00 | 47,311,998.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 100,000.00 | 35,998.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,400,000.00 | 47,276,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,570,000.00 | 2,200,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,570,000.00 | 2,200,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,134,453.00 | 20,257,918.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,353,000.00 | 18,961,276.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 961,175.00 | 961,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 171,500.00 | 160,689.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 24,178.00 | 24,178.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 66,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 84,600.00 | 84,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,500,000.00 | 13,449,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,300,000.00 | 4,799,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,200,000.00 | 8,650,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,195,848.59** | **66,024,404.01** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,965,000.00 | 63,140,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 62,640,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,965,000.00 | 500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 2,884,404.01 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 2,884,404.01 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 230,848.59 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 230,848.59 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,437,979.00** | **29,213,990.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,437,979.00** | **29,213,990.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,437,979.00** | **29,213,990.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,437,979.00 | 29,213,990.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,437,979.00 | 29,213,990.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-8,437,979.00** | **-29,213,990.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 702,478,700.00 | 699,629,295.99 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 702,478,700.00 | 699,629,295.99 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 639,338,700.00 | 636,489,295.99 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 429,582,400.00 | 426,733,848.07 |
| 210101 | Үндсэн цалин | 271,082,600.00 | 270,440,017.32 |
| 210102 | Нэмэгдэл | 135,649,600.00 | 135,544,992.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,850,200.00 | 20,748,838.57 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,997,000.00 | 53,996,927.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,509,800.00 | 37,234,199.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,121,800.00 | 4,222,132.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,297,400.00 | 3,344,145.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 824,400.00 | 835,986.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,243,600.00 | 8,360,464.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,441,100.00 | 17,441,096.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,540,800.00 | 1,540,799.55 |
| 210302 | Түлш, халаалт | 12,895,500.00 | 12,895,497.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,804,800.00 | 1,804,800.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,884,200.00 | 25,883,817.08 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,575,000.00 | 10,574,999.34 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,100,000.00 | 8,099,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,200,000.00 | 2,199,817.74 |
| 210404 | Ном, хэвлэл | 409,200.00 | 409,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,600,000.00 | 3,600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 75,776,000.00 | 75,775,988.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,000,000.00 | 8,999,988.00 |
| 210602 | Тавилга | 19,500,000.00 | 19,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 47,276,000.00 | 47,276,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,200,000.00 | 2,200,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,200,000.00 | 2,200,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,258,000.00 | 20,257,918.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,961,300.00 | 18,961,276.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 961,200.00 | 961,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 160,700.00 | 160,689.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 24,200.00 | 24,178.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 66,000.00 | 66,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 84,600.00 | 84,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14200000.00 | 14199700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,800,000.00 | 4,799,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,400,000.00 | 9,400,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 63140000.00 | 63140000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 63,140,000.00 | 63,140,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 62,640,000.00 | 62,640,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 702,478,700.00 | 699,629,295.99 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 702,478,700.00 | 699,629,295.99 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 702,478,700.00 | 699,629,295.99 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 19 | 19 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 5 | 5 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13 | 13 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 3/104 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Прокурорын Тамгын газар нь Прокурорыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслах, прокурорын газрын бие даасан байдал, прокурорын хараат бус байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.

Байгууллагын үйл ажиллагаанд инновац нэвтрүүлэх, Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, Прокурор, ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, чадварлаг прокурор, ажилтныг сайшаан дэмжих, прокурор, ажилтны суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлж ажиллах зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 492.9 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 7.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31.5 сая төгрөг буюу 14.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | 0 | 0 | 0 |
| **Авлага** | 0.06 | 0 | -0.06 |
| **Бараа материал** | 5.5 | 10.3 | 4.7 |
| **Үндсэн хөрөнгө** | 207.2 | 234.1 | 26.8 |
| **Нийт хөрөнгө** | **212.8** | **244.4** | **31.6** |
| **Өр төлбөр** | 0.06 | 0 | -0.06 |
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | **212.8** | **244.4** | **31.6** |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **212.8** | **244.4** | **31.5** |

Бараа материалын дансны үлдэгдэл 10.3 сая төгрөг болж 4.7 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд Прокурорын ерөнхий газраас хангамжийн материал 3.0, бусад 0.2 нийт 3.2 сая төгрөгийн материал үнэ төлбөргүй ирсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 234.1 сая төгрөг болж 26.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 29.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан, Улсын ерөнхий прокурорын газраас 23.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2.0 сая төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүйгээр нийлүүлсэн нь гол нөлөөлжээ.

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 195.0 сая төгрөг буюу 36.3 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын данс байна. Тодруулбал тайланд онд өмнөх оны санхүүжилт 222.6 сая төгрөгөөр нэмэгдэж, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 28.8 сая төгрөг болсон байна. Энэ нь 3.2 сая төгрөгийн материал, 25.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нийт 28.8 сая төгрөгийн хөрөнгө, материал үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 207.6 сая төгрөг буюу 42.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл, АО-оос НД шимтгэлийн зардал, урсгал зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа ажил үйлчилгээний бусад, урсгал зардал буюу тэтгэвэрт гарах олгох нэг удаагийн тэтгэмж  зэрэг зардлууд байна.

Энэ нь орон тоо, хоол унааны хөнгөлөлт 72.0 сая, тэтгэвэрт гарсны тэтгэмж 62.4 сая, урсгал зардал 42.0 сая, бараа үйлчилгээний зардал 11.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 11.5 сая  төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 641.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 641.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 117.8 сая төгрөгөөр бууруулж, 523.8 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор тус байгууллагын төсвийг тайлант хугацаанд 5-6 удаа өөрчлөн 178.7 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 702.4 сая төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 702.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 699.6 сая төгрөгийг зарцуулж, 2.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 699.6 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа унаа хоол болон бусад нөхөн олговрын зардал 2.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Прокурорын газар нь тайлант оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 чиглэл хэрэгжүүлэхээр тусгаж гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг УЕПГ-т хүргүүлсэн.

Тухайн байгууллагын 2021 онд хэрэгжүүлсэн “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний биелэлтийг 97.0 хувьтай дүгнэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 124 мэдээлэл, 281.5 сая төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн,бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сүхбаатар аймгийн Прокурорын газарт "Итгэл" үзүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар шилэн данс, үндсэн хөрөнгө болон түлш халаалтын зардалтай холбоотой нийт 3 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

***2. Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулаагүй нь Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын 1 дэх “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолуур суурилуулах ажлыг 2020 оны 3-р улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай” заалттай нийцэхгүй байна.

*2.2. Өгсөн зөвлөмж:*

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулж, дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 461 дүгээр тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж, Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

**3 .Шилэн данстай холбоотой**

3.1 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудаст 281.5 сая төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*3.2 Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Сүхбаатар аймгийн Прокурорын газрын | 3 | | | | | | | | 3 | 0 |
| | | | | | | | | | | | |